

ВЬЕТНАМЫН СОЁЛЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ, ҮР НӨЛӨӨ

(This research is funded by Vietnam National Foundation for Science and Technology Development (NAFOSTED) under grant number V1.2-2012.12)

Фам Хон Тай*

Нгуен Ту Ту Фьон**

***Abstract:** A reform of cultural policies, including the policies for development of cultural industries as one of the contents of Doi Moi (Renovation), has been carried out in Vietnam since 1986. The radical changes in the cultural policies, especially the acceptance of market-based principles in cultural activities have created initial positive conditions for development of the cultural industries in Vietnam. In practice, such policy and institutional changes have been creating major preconditions for the Vietnamese cultural industries to be founded and developed. Yet, the realities of development of the cultural industries at present have exposed a number of weaknesses and challenges, requiring further adjustments and improvements from the policy-makers.*

***Key words:** Vietnam, reform, cultural policy*

1986 оноос Вьетнам улс шинэчлэлт (Дой Мөй)-ийн хүрээнд соёлын бодлогын шинэчлэлт явуулж эхэлсэн бөгөөд үүнд соёлын салбарын хөгжлийн бодлого ч багтах болов. Соёлын бодлогод гарсан эрс өөрчлөлт, тэр дундаа соёлын үйл ажиллагаанд зах зээлийн зарчмыг хүлээн зөвшөөрсөн явдал нь Вьетнамын соёлын салбарын хөгжилд анхны эерэг нөхцөл байдлыг бий болгосон. Үнэндээ бодлогын

*. Доктор (Ph.D), дэд профессор, Зүүн хойд Ази судлалын хүрээлэнгийн дэд захирал, Вьетнамын Нийгмийн шинжлэх ухааны академи (VASS)

**.. Доктор (Ph.D), Соёлын хөгжлийн төвийн захирал, Вьетнамын Соёл, урлаг судлалын үндэсний хүрээлэн (VICAS)

болон институцийн энэхүү өөрчлөлтийн дүнд Вьетнамын соёлын салбар цаашдаа хөгжих урьдчилсан нөхцөлөөр хангагдсан юм. Гэсэн ч, өнөөгийн соёлын салбарын хөгжилд хэд хэдэн сул тал, сорилт оршоор байгаа нь бодлого боловсруулагчдад цаашид зохицуулалт хийж сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.

Вьетнамын Коммунист намын удирдлага дор өрнөж буй шинэчлэлт (Дой Мөй)-ийн үйл явц нь 30 жилийн турш үргэлжилж байна. Эдийн засгийн шинэчлэлтийг гол болгосон энэхүү хөгжлийн үйл явц нь Вьетнамын хөгжлийн шинэ эрин үеийг нээсэн билээ. Эдийн засгийн шинэчлэлттэй харьцуулахад соёлын салбарын шинэчлэлтийг түлхүү анхаарч үзсэн ба энэ нь соёлын бодлогод нөлөөлж, соёлын үйл явцад эерэг өөрчлөлт бий болоход хүргэсэн. Энэхүү судалгааны ажлаар Вьетнамын соёлын хөгжлийн бодлогын шинэчлэлтийг Вьетнамын Коммунист намын сэтгэлгээний өөрчлөлт дээр тулгуурлан одоогийн Вьетнамын соёлын бодит хөгжилд уг бодлого шинэчлэлт нь хэрхэн нөлөөлсөн талаарх дүгнэлт өгөхийг хичээсэн болно.

1.1986 оноос өнөөг хүртэлх Вьетнамын соёлын салбарын хөгжлийн бодлогын шинэчлэлт

1.1. Соёлын салбарын удирдлагаын түвшинд соёлын зах зээлийг хүлээн зөвшөөрсөн нь

Дой Мөй-оос өмнө Вьетнамд соёлын салбарын үйл ажиллагааг төрөөс санхүүжүүлж, төв, орон нутгийн түвшинд адил заавар, чиглэлээр хэрэгжүүлж байв. Товчхондоо, соёлын үйл ажиллагаа нь зах зээлийн дүрэмд захирагддаггүй, ашиг хардаггүй, алдагдалд санаа зовдоггүй бизнесийн бус салбар байлаа. 1986 оны шинэчлэлт (Дой Мөй)-ийн дараагаар соёлын салбарт үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын удирдлагууд соёлын үйл ажиллагааны эдийн засгийн асуудалд илүү анхаарал хандуулах болов. Үүний нэг жишээ нь төрөөс соёлын үйл ажиллагаанд зарцуулах төсвийг тодорхой хэмжээгээр бууруулсан явдал юм. Соёл, урлагийн олон лекц, семинарт эдийн засгийн үнэ цэнэ, ач холбогдолын талаар хэлэлцэх болсон. Энэхүү асуудал нь Вьетнамын Коммунист намын баримт бичгүүдэд тусгагдах болсоноор ХХ зууны 90-ээд оны сүүлээс төр засгийн зүгээс уг асуудалд бодитой анхаарал хандуулж эхэлсэн юм. 1998 оны Намын Төв Хорооны VIII бүгд хурлын

V хуралдаанаас гарсан тогтоолд соёлын хөгжлийн эдийн засгийн бололцоо, соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг иргэдэд илүү хүртээлтэй болгох боломжийг нэмэгдүүлэх шинэ санаачлага хэрэгтэй байгааг онцолсон.¹ 2004 оны Намын Төв Хорооны IX бүгд хурлын X хуралдааны баримт бичигт соёлын хөгжилд эдийн засаг чухал болохыг, эдийн засаг болон соёлын хөгжил харилцан уялдаатай байх хэрэгтэйг, соёлын үйл ажиллагаа болон бүтээгдэхүүнийг нийгэмшүүлэх шаардлагатайг онцлон тэмдэглэсэн байдаг. Эдгээрийг нийгэм-эдийн засгийн болон соёлын хөгжлийн бодлогыг сайжруулах үндэс суурь гэж үзэж болно. 2008 онд Вьетнамын Коммунист намын Улс төрийн товчооноос гаргасан шинэ эрин үеийн уран зохиол болон урлагийн хөгжлийн тухай 23-р тогтоол нь энэхүү салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийг бий болгохын зэрэгцээ сайн чанарын бүтээгдэхүүн, үйлчилгээг гадаад улс орнууд руу гаргах, олон улсын соёлын солилцооны орчин үеийн цэг болгоход хувь нэмэр оруулах зорилготой байсан.

Намын Төв Хорооны VIII бүгд хурлын V хуралдаанаас гаргасан баримт бичиг хэрэгжиж эхэлсэнээс хойш 15 жилийн дараа буюу 2015 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн Вьетнамын Намын Төв Хорооны IX бүгд хурлаар “Улс орны тогтвортой хөгжлийн шаардлагыг хангахуйц Вьетнамын соёл болон ард түмнийг хөгжүүлэх” тухай 33 дугаар тогтоолыг баталсан байна. Уг тогтоолын гол зорилго нь Вьетнамын соёлын чадамж, онцлог чанарыг гаргаж ирэх, дэмжих, соёлыг гадаад улсуудад түгээх явдал байсан юм. Мөн уг тогтоолд “институцийн шинэчлэл хийж сайжруулах, соёлын хөгжил болон бүтээн байгуулалтанд эрх зүйн таатай орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаар дурджээ. Түүнчлэн оюуны өмчийн эрх болоод бусад эрхтэй холбогдуулан хууль сахиулах байгууллагуудын ойлголтыг сайжруулах, төв, орон нутгийн хууль сахиулах байгууллагууд ба удирдах байгууллагуудын бүтээмжийг дээшлүүлэх, бататгахыг зорьсон байна”.²

1. Văn kiện Hội nghị lần thứ năm Ban Chấp hành Trung ương khóa VIII, (ВКНамын Төв Хорооны VIII бүгд хурлын V хуралдааны тэмдэглэл), Nxb Chính trị quốc gia, Hà Nội, 1998, tr.54-98.

2. Đảng Cộng sản Việt Nam, Nghị quyết. Trung ương 9 khóa XI, (Вьетнамын Коммунист нам, Намын Төв Хорооны IX бүгд хурлын IX хуралдааны тогтоол, <http://huc.edu.vn/chi-tiet/3057/Nghi-quyet-trung-uong-9-khoa-XI.html>)

Вьетнамын Коммунист намын тогтоолуудын өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн нь тус улсын соёлын хөгжлийн бодлого боловсруулах чухал үндэс суурь болж чаджээ.

1.2. Соёлын бодлогын шинэ тогтолцоог бий болгосон нь

Намын Төв Хорооны VIII бүгд хурлын V хуралдааны тогтоол батлагдсаны дараа (1998 он) Үндэсний Ассамблей, Засгийн газар болон бусад бүх түвшний удирдлагууд шат дараатайгаар, харилцан уялдаа холбоотой баримт бичгүүдийг боловсруулж, гаргасаар ирэв. 2020 он хүртэлх Соёлын хөгжлийн стратеги нь (Ерөнхий сайдын 2009 оны 5 дугаар сарын 6-ны өдөр гаргасан 581/QD-ТТg тоот тушаал) Вьетнамын Коммунист намаас гаргасан соёлын хөгжлийн чиг хандлага, үзэл баримтлалыг бодит болгох, зохион байгуулахад дэмжлэг үзүүлэхүйц чухал баримт бичиг болсон юм. 2005 оны “*ЮНЕСКО-ийн Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай конвенц*”-ийн дагуу 2007 онд “Вьетнамд соёлын хөрөнгө оруулалт хийхийг урамшуулах, түүнд тохирсон хууль, эрх зүйн орчин, санхүүгийн механизмыг бий болгох” хөтөлбөр гарган хэрэгжүүлсэн. Уг хөтөлбөрийн гол зорилго нь тохиромжтой санхүүгийн механизм ба хууль, эрх зүйн орчин шинээр бүрдүүлж, илүү үр дүнтэй хөрөнгө оруулалт хийхийн зэрэгцээ соёлын хөгжлийг бодлогын зөвлөмж болон стратегийн үйл ажиллагаагаар хангах явдал байсан юм.

1986 оноос хойш Вьетнамын Үндэсний Ассамблей соёлын салбарыг бүх талаас нь хөгжүүлэх тухай хэд хэдэн хууль, эрх зүйн баримт бичиг баталж, бүтээлч соёл урлагийн үйл ажиллагааг хөгжүүлэх үүднээс холбогдох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж өгсөн. Тухайлбал, 1989 онд батлагдан, 1999, 2009 онд өөрчлөлт орж, 2006 оноос хэрэгжиж эхэлсэн Кино театрын тухай хууль, 2013 онд баталсан Кино театрыг хөгжүүлэх тухай 2020-2030 он хүртэлх стратеги, 2001 оны Зар сурталчилгааны тухай тогтоомж, 2012 оны Зар сурталчилгааны тухай хууль, 2001 онд батлагдан, 2009 онд өөрчлөлт орсон Соёлын өвийн тухай хууль, 2000 оны Номын сангийн тухай захирамж, 2005 оны Оюуны өмчийн тухай хууль... зэргийг дурдаж болно.

Үүнээс гадна урлагийн тоглолт, загварын шоу, гоо сайхны тэмцээн, загварын тэмцээний тухай хууль тогтоомжийг 2012 онд Засгийн

газраас баталсан бөгөөд тэдгээр нь тогтмол шинэчлэгдэж байдаг. 2013 оноос хойш уран зураг, фото зураг, үзэсгэлэн зэрэг соёлын бусад үйл ажиллагааг явуулах таатай орчноор хангахад чиглэсэн баримт бичиг гарган зохицуулж байна. Тухайлбал, 1998 онд Вьетнамын Засгийн газар бүх салбарын соёл, урлагийн үйл ажиллагааны захиргааны зөрчлийг зохицуулах, нийгмийн дэг журмыг тогтоох, соёлын үйл ажиллагаанд хувь хүн, байгууллагын эрх ашгийг хамгаалах зорилготой хэд хэдэн баримт бичиг боловсруулсан.

1986 оноос өнөөг хүртэл хэрэгжүүлж буй соёлын бодлогоос харахад, Вьетнам улс Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн болсоноос хойш соёлын салбарын хөгжлийг дэмжих анхны алхамуудыг хийж эхэлсэн байна. Вьетнамын Засгийн газар болон Намаас гаргасан соёлын хөгжлийн тухай баримт бичгийн тогтолцоо үндсээрээ өөрчлөгдсөн гэж үзэж болно. Үүнд:

1. Соёлын салбарын бүтээгдэхүүнийг зах зээлийн дүрмээр бараа хэмээн хүлээн зөвшөөрөх,
2. Соёлын салбарыг эдийн засгийн бодлогоор, эдийн засгийн салбарыг соёлын бодлогоор дэмжин, соёлын бүтээгдэхүүнд зах зээлийн таатай орчин бүрдүүлэх,
3. Үйл ажиллагааны механизмыг шинэчлэх, олон нийтийн соёлын байгууллагуудыг дэмжих, соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг нийгэмшүүлэх, соёлын хөгжлийг дэмжих бодлого авч хэрэгжүүлэх.

Соёлын институцыг шинэчлэхэд нэг хэв маягтай баримт бичиг боловсруулах нь төрийн удирдлагад ашигтай арга хэрэгсэл гэж үзсэн ба энэ шинэчлэлт нь нэг талаас соёлын салбарын хөгжилд эерэг нөлөө үзүүлсэн ч нөгөө талаас Вьетнамын удирдагчид болон бодлого боловсруулагчдад багагүй сорилт учруулжээ.

1.3. Вьетнамын соёлын салбарын хөгжлийн стратеги боловсруулагдсан нь

Одоогоор Вьетнам улс “Соёлын салбарыг 2020-2030 онд хөгжүүлэх стратеги”-ийг хэрэгжүүлж байна. Дэлхийн соёлын түүхээс үзэхэд, стратегчид Вьетнамын соёлын салбарын хөгжлийн бодит байдлыг дараах байдлаар тодорхойлж байна. “Соёлын салбар гэдэг

нь соёлын баялаг, шинжлэх ухаан, технологийн ололт амжилтанд тулгуурлан, үйлдвэрийн горим ашиглан соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд бүтээлчээр түгээх, солилцох болон худалдаалахыг хэлнэ”.³

Стратеги боловсруулах явцад хийсэн судалгааны үр дүнгээс үзэхэд Вьетнамын одоогийн соёлын салбарын дийлэнх нь шинээр байгуулагдсан, жижиг, дунд бизнесийн бүтэцтэй байжээ. Бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэхээс түгээх хүртэлх бүх үе шатны дийлэнхийг төрийн байгууллагууд хийж байна. Хувийн хэвшлийн болоод төрийн бус байгууллагууд гол төлөв бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд түгээх эсвэл эргэлдүүлэх үйл явцад оролцдог ч эмх замбараагүй, мэргэжлийн бус байдаг.

Төрийн удирдлагын үйл ажиллагаан дээр үндэслэн хийсэн судалгаанаас харахад Вьетнамын соёлын салбарын бүтэц 12 хэсгээс бүрдэж байна. Үүнд: 1) Зар сурталчилгаа, 2) Архитектур, 3) Програм хангамж, цахим тоглоом, 4) Гар урлал, урлаг, 5) Зохион бүтээх; 6) Кино театр, 7) Хэвлэл мэдээлэл, 8) Загвар, 9) Урлагийн үзүүлбэр, 10) Уран бүтээл, гэрэл зургийн үзэсгэлэн, 11) Телевиз, радио, 12) Соёлын аялал жуулчлал.

Соёлын салбарын ойлголт, бүтцийг тодорхойлох замаар Вьетнамын соёлын салбарыг 2020-2030 онд хөгжүүлэх стратегийн гол зорилтыг ийнхүү тодорхойлсон. Соёлын салбарыг хөгжүүлж, эдийн засгийн өсөлтийн гол тулгуур болгох, соёлын нөөц, оюуны чадамж, бүтээлч чадварыг орчин үеийн технологитой хослуулан олон төрлийн соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгох, улмаар ДНБ-ийг өсгөх, ажлын байр нэмэгдүүлэх, хүн амын болон экспортын хэрэгцээг хангах чадамжтай болох, соёлын бүтээгдэхүүний зах зээлийг өргөжүүлэх, давуу тал, боломж ихтэй үйлдвэрүүдэд түлхүү анхааран, бүтээгдэхүүний нэр хүндийг өсгөх, олонд таниулах зэрэг хэмээн тодорхойлсон.

Тухайлбал, 2020 он гэхэд соёлын салбар Вьетнамын ДНБ-ний 3 хувийг эзлэх ба ажлын байр шинээр бий болгоно. 2030 он гэхэд соёлын

3. Bộ Văn hóa Thể thao và Du lịch, Dự thảo “Chiến lược phát triển các ngành công nghiệp văn hóa Việt Nam đến năm 2020, tầm nhìn đến năm 2030”, (Вьетнамын соёлын салбарыг 2020-2030 онд хөгжүүлэх стратеги), 2016.

салбар шинээр илүү их ажлын байр бий болгон, үндэсний эдийн засгийн чухал бүрэлдэхүүн болох ба Вьетнамын ДНБ-ийн 7 хувийг эзэлнэ.

Дээр дурдсан зорилтуудад хүрэхийн тулд “Вьетнамын соёлын салбарын хөгжлийн 2020-2030 он хүртэлх стратеги”-д доорх 9 арга замыг дэвшүүлсэн байна. Үүнд:

1. Сэтгэлгээгээ өөрчлөх, соёлын бүтээгдэхүүн үйлдвэрлэх чадамжтай, өргөн цар хүрээ бүхий эдийн засгийн салбарыг бий болгох, ДНБ-д хувь нэмэр оруулах болон шинээр ажлын байр бий болгох;
2. Яам, салбар хоорондын хамтын ажиллагааны механизмыг дахин нягтлах, өөрчлөх, бий болгох, сайжруулах. Хөрөнгө, татвар, газрын бодлогыг онцлон анхаарч, уран бүтээлчид, шинээр эхэлж буй бизнесүүдийг дэмжих, соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, нэр хүндийг өсгөх;
3. Олон улсын хамтын ажиллагаа, солилцоо, хамтарсан компанийн уялдаа холбоог бэхжүүлэх, шинжлэх ухаан, технологийн ололт амжилтыг ашиглах, дэлхийн соёлын салбарын хөгжлөөс туршлага судлах;
4. Гадаад, дотоодод соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлээ өргөжүүлэх боломжийг бий болгох, хөгжүүлэх;
5. Соёлын бизнесийг цахимжуулах, гадаад, дотоодод хүчтэй, нэр хүндтэй, өрсөлдөх чадвар сайтай бизнесийн бүлэг байгуулах;
6. Соёлын салбарт статистик болон мэдээллийн сан бий болгох;
7. Оюуны өмчийн хуулийн хэрэгжилтийг сайжруулах;
8. Соёлын салбарын хүний нөөцийг бэлтгэх, сонгох, дэмжих, сайжруулах, соёлын салбарын өндөр хөгжилтэй орны сайн бэлтгэгдсэн, туршлагатай мэргэжилтнүүдийг Вьетнамд урьж, тусгай цалин санал болгон ажиллуулах;
9. Соёлын салбарын хөгжилд тохирсон стратеги, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах яамд, орон нутгийн эрх бүхий байгууллага хооронд хүчтэй уялдаа холбоо тогтоож, хамтын ажиллагааг бэхжүүлэх зэрэг болно.

Бодлого боловсруулагчдын үзэж байгаагаар “Вьетнамын соёлын салбарыг 2020-2030 онд хөгжүүлэх стратеги”-ийн боловсруулалт, хэрэгжилт нь Вьетнамын соёлын салбарын дэлхийд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх бөгөөд дотоодын нөөцийг бэхжүүлэх юм.

2. Вьетнамын соёлын салбарын хөгжлийн бодлогын шинэчлэлтийн үр нөлөө

2.1. Ололт, амжилт:

- *Сэтгэлгээний өөрчлөлт, соёлын салбарын тухай ойлголт*

Өнгөрсөн хугацаанд соёлын салбарын хөгжлийн удирдлагын механизмд өөрчлөлт гарсан. Зах зээлийн зарчмыг хүлээн зөвшөөрөн, төрийн соёлын байгууллагуудын журмыг шинэчлэн, соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг нийгэмшүүлэх, соёлын салбарт эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэн, соёлын тодорхой салбарт тусгай стратеги хэрэгжүүлсэн. Үүний зэрэгцээ соёлын салбарын хөгжлийн 2020-2030 хүртэлх стратеги боловсруулахаар хүчин чармайлт гарган ажилласан байна.

Ингэснээр Вьетнамын соёлын салбарын байр суурь, үүрэг болон бүтцийн тухай ойлголт өөрчлөгдөж, соёлын үйл ажиллагаа болон удирдлагад эерэг бөгөөд томоохон өөрчлөлт авчрах болов. Соёлын үйл ажиллагааг төрийн удирдлагын салбар бус зах зээлийн дүрэмд захирагдсан бизнесийн салбар хэмээн харах болов.

Соёлын салбарын үүрэг, байр суурь өөрчлөгдсөнөөр соёлын зах зээлд олон төрлийн бизнесийн горим бий болж, түгээх сувгууд бий болжээ.

Бодлогын болон институцийн шинэчлэл нь соёлыг таашаадаг хүмүүсийн хэрэгцээг хангасан соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох таатай орчинг бүрдүүлсэнээс гадна хөгжил болон интеграцийн үйл явцад хууль, эрх зүйн тогтолцоот соёлын бодит нөлөөг нэмэгдүүлсэн.

- *Өмчлөх хэлбэрийг төрөлжүүлэх, зах зээлийг өргөжүүлэх болон соёлын салбарын хөгжлийг дэмжих*

Вьетнамын соёлын бодлогын өөрчлөлт нь дан төрийн өмч байснаа төрөлжин олон бүрэлдэхүүний өмч (төрийн эзэмшил, төрийн бус

эзэмшил, холимог эзэмшил) болсон бөгөөд энэ нь соёлын дэд бүтцийн хөгжилд хөрөнгө оруулалт хийсэнтэй нягт холбоотой.

Өмчлөлийн бүтэц өөрчлөгдсөний зэрэгцээ Вьетнамын соёлын үйл ажиллагааны төсвийн зардлын 1.8%-ийг улсын төсөв эзлэх болов.

2015 онд соёлын хөгжилд 26.7 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн ба үүнээс гадна 12.7 сая ам.долларыг Үндэсний зорилтот соёлын хөтөлбөрт зарцуулсан байна.⁴ Соёл урлагийн үйл ажиллагаанд улсын төсвөөс санхүүгийн тусламж үзүүлсэн. Соёлын салбарын хөгжилд болон урлагийн үйл ажиллагаанд татварын бодлогоор дэмжлэг үзүүлсэн ба хагас төрийн болон төрийн бус соёлын сангийн байгууллага бий болох таатай нөхцлийг бүрдүүлсэн. Эдгээр бодлого, механизмын хүрээнд 2015 он гэхэд соёлын зах зээл өргөжин тэлсэн.

2015 оны сүүлээр соёлын салбар улсын хэмжээнд төрөлжсөн өмчийн бүрэлдэхүүнтэй болсон. Үүнд: кино театр, театр, музей, соёлын төвүүд, соёлын бүтээгдэхүүний дэлгүүр болон хэвлэл мэдээллийн байгууламж багтаж байна. 2015 оны статистикийн мэдээнээс харахад, нийт 561 тэнхимтэй 156 кино театр бий болсон байсан.⁵ Кино театруудын 80-аас илүү хувь нь гадаадын хөрөнгө оруулалттай. Вьетнам дахь музейн тогтолцоо ч мөн дээшилсэн ба нийт 149 музейтэй (124 улсын музей, 25 хувийн хэвшлийн музей) болсон байна.

Түүнчлэн нийт 66 телевиз, радио үйл ажиллагаа явуулдагаас хамгийн том хоёр нь Вьетнамын дуу хоолой (VOV) болон Вьетнамын Телевиз (VTV), нэг нь сайд нарын шууд удирдлага доорх телевиз, 64 нь орон нутгийн телевиз, радио байдаг байна. Хэвлэлийн хувьд 63 төрлийн хэвлэлийн компани байгаагаас, 44 нь хувийн хэвшлийн, 19 нь 100% төрийн өмчит хязгаарлагдмал хувьцаат компани юм. Хэвлэлийн салбарын хувьд хэвлэгдсэн номын тоо 15-20%, номын гарчиг 8-10%, хэвлэгдсэн хуудасны тоо 10-15%-аар өссөн үзүүлэлттэй байна.⁵ Вьетнамын соёлын хөгжлийн бодлого өөрчлөгдөн, шинэчлэгдсэнээр

4. Dẫn theo số liệu thống kê của Dự thảo “Chiến lược phát triển các ngành công nghiệp văn hóa Việt Nam đến năm 2020, tầm nhìn đến năm 2030”, (Вьетнамын соёлын салбарыг 2020-2030 онд хөгжүүлэх стратеги).

5. Theo số liệu thống kê của Công ty Thiên Ngàn-Galaxy, (ThienNgan-Galaxy компаниас гаргасан статистик мэдээ), 2015.

5. Dẫn theo số liệu thống kê của Dự thảo “Chiến lược phát triển các ngành công nghiệp văn hóa Việt Nam đến năm 2020, tầm nhìn đến năm 2030”, (Вьетнамын соёлын салбарыг 2020-2030 онд хөгжүүлэх стратеги).

кино үйлдвэрлэл, түгээлтийн байгууллагууд болон аялан тоглогчид зэрэг төрийн бус удирдлагатай соёлын нэгжүүдийг төрийн өмчит соёлын бизнесийн байгууллага болгох нөхцөл бүрдсэн.

Дангаар өмчлөх бүтэц байхгүй болсоноор зарим өөрчлөлтүүдийг хийх боломжтой болсон. Тухайлбал, соёлын үйл ажиллагааг нийгэмшүүлэх, төрөлжсөн өмчлөх хэлбэрийг харгалзан соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээнд тохирсон бодлого хэрэгжүүлэх, олон улсын интеграцийн нөхцөлд тохирсон зах зээлийг өргөжүүлэх, соёлын бизнесийн өрсөлдөх чадварыг сайжруулах зэрэг болно.

- *Бодлогын шинэчлэлт соёлын салбарыг хөгжих сэдэл болсон нь*

Соёл урлагийн байгууллагуудын хэрэгжүүлж буй бие даасан механизм нь соёлын салбарт шинэ нөхцлийг бий болгох, нийгэм, эдийн засгийн ашиг сонирхолын хослох боломжоор хангах, соёлын идэвхтнүүдийн бие даасан, хариуцлагатай, бүтээлч чадварыг сайжруулсан байна. Зарим жишээ дурдвал:

Кино театрын салбарт: Дой Мөйн шинэчлэлтээс өмнө Вьетнамын кино театрын бүх үйл ажиллагааг төрөөс удирдан зохицуулдаг байсан ба үзэгчдийн сэтгэлийг ихээр хөдөлгөдөг бүтээлүүд гарсан хэдий ч цөөн байжээ. 1986 оноос хойш кино театрын үйл ажиллагаанд зориулсан улсын төсөв огцом буурч, төрийн кино студи болонхувийн хэвшлийнхэн хамтран ажиллах боломжийг бий болгож өгсөн юм. Энэ нь Дой Мөйн шинэчлэлт Вьетнамын киноны салбарын хөгжилд хувь нэмрээ оруулах эхлэл болсон. XX зууны 90-ээд оны кино театрын салбарын хөгжлийг тодорхойлох 10 жилийн бодлогод нийцүүлэн Вьетнамын Засгийн газар зарим шаардлагыг тогтоосон байна. Энэ нь тэр үед хятад, солонгос, америкийн кинонд эзлэгдээд байсан Вьетнамын кино зах зээлийг зөв голдиролд оруулахад ихээхэн түлхэц болжээ.

2015 оны статистикийн үзүүлэлтээс харахад, улсын хөрөнгө оруулалтаар 8 кино (кино театруудад үзүүлсэн), 36 баримтат кино, 10 хүүхэлдэйн кино хийсэн бол хувийн кино үйлдвэрлэгчид 32 кино, 17 баримтат кино, 30 хүүхэлдэйн кино хийсэн байна. 2015 онд киноноос олсон нийт орлого 102.1 сая ам.доллар буюу 2014 онтой харьцуулахад

(84.3 сая ам.доллар) бараг 21%-иар өссөн байна.⁷ Тоо хэмжээ, чанарын энэхүү өсөлт нь өөрчлөлт шинэчлэлтийн явцад хэрэгжүүлсэн оновчтой бодлогын үр дүн юм. 2015 онд, дотоодын нэг киноноос олсон дундаж орлого 780,4 мянган ам.доллар байсан бол гадаадын нэг киноноос олсон орлого 391,6 мянган ам.доллар байв. Энэхүү үзүүлэлт нь Вьетнамын уран бүтээлчдийн хийсэн киноны тоо зах зээлдэх нийт киноны 18%-ийг эзэлж байгааг харуулж байна. Нэг вьетнам киноны орлогыг (731.3 мянган ам.доллар) гадаадын киноны орлого (349,6 мянган ам.доллар)-той харьцуулахад хоёр дахин их байсан байна.⁸

Урлагийн салбарт: Вьетнам түүхэндээ олон төрлийн урлагийн жүжигчидтэй байсаар ирсэн. Уламжлалт урлагийн болон орчин үеийн дуу, бүжиг, хөгжим, симфони, найрал дуу, дуурь, балет, ардын дуурь, жүжиг, мэргэжлийн хүмүүс нь Вьетнамд урлагийн хөгжил хүчтэй байгааг харуулдаг. Үүний дотроос дуу бичлэгийн бизнесийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын тоо хэмжээ өсч, боловсруулсан дуу, бүжиг, хөгжмийн тоглолт нэмэгдэх болжээ. Соёл, урлагийн газраас гаргасан мэдээгээр, 2015 онд энэ салбарын орлого 5.2 сая ам.доллар хүрнэ гэсэн тооцоотой байсан хэдий ч түүнээс 5 хувиар өссөн байна.⁹ Уламжлалт урлагийн өвийг хадгалах чиглэлд сайн дурынханы оролцоог дэмжих асуудлаар оновчтой бодлого явуулсаны дүнд энэхүү амжилтанд хүрчээ.

Сүүлийн жилүүдэд Вьетнамын соёлын салбарын хөгжлийн бодлого олон улсын интеграцийн чиг хандлагад нийцүүлэн соёлын бүтээгдэхүүн үйлдвэрлэлд орчин үеийн шинжлэх ухаан, технологийн ололтыг ашиглах таатай нөхцлийг бий болгож, бүтээлчээр хэрэгжиж байна. Соёлын салбарт зарим дэвшил бий болжээ. Тухайлбал, 2014 онд програм хангамж, цахим тоглоомын салбарт 500 гаруй бизнес эрхлэгчид 1,404 тэрбум гаруй ам.долларын нийт орлого олж, 60.000 гаруй ажлын байрыг шинээр бий болгож, нэг ажилчны жилийн дундаж орлого 19,000 ам.долларт хүрсэн байна. Дотоодын зах зээл

7. Nguồn: Báo cáo tổng kết Bộ Văn hóa, Thể thao và Du lịch năm 2015, (Соёл, спорт, аялал жуулчлалын яамны 2015 оны нэгдсэн тайлан мэдээ).

8. Dẫn theo số liệu thống kê của Dự thảo “Chiến lược phát triển các ngành công nghiệp văn hóa Việt Nam đến năm 2020, tầm nhìn đến năm 2030”, (Вьетнамын соёлын салбарыг 2020-2030 онд хөгжүүлэх стратеги).

9. Nguồn: Báo cáo tổng kết Bộ Văn hóa, Thể thao và Du lịch năm 2015, (Соёл, спорт, аялал жуулчлалын яамны 2015 оны нэгдсэн тайлан мэдээ).

дээр амжилттай байсан энэ чиглэлийн зарим бизнес эрхлэгч өөрийн бизнесийг гадаад зах зээлд нээж чаджээ. Вьетнам одоогоор 74 телевизийн суваг, 9 радио сувагтай болсон байна. Дотоод, гадаадын 40 сувгийг¹² өргөн нэвтрүүлгийн дөрвөн төрлийн технологийг ашиглан кабелийн телевизийн тусламжтайгаар гэртээ шууд үзэх боломжтой болсон байна. Хэрэглэгчийн тоо сүүлийн жилүүдэд дунджаар 8 хувиар өссөн ба 2014 онд гэхэд 7 сая болов. 2014 онд Вьетнамын үндэсний телевизийн (VTV) нийт орлого 464 сая ам.долларт хүрчээ.¹¹

Товчоор хэлбэл, соёлын салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татахын тулд хөрөнгө оруулалтын шинэ нөхцлийг бий болгож, эдийн засаг, соёлын зөв бодлого явуулсан нь Вьетнамын ДНБ-ийг нэмэгдүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулсан байна. 2015 оны албан бус мэдээгээр, Вьетнамын соёлын салбар ДНБ-ний бараг 2.68%-ийг эзэлж, 8.039 тэрбум ам.доллар болжээ.

2.2. Зарим сул талууд:

Соёлын салбар хараахан бүрэн хүлээн зөвшөөрдөөгүй ба хамрах хүрээ хязгаарлагдмал: Хэдийгээр Вьетнамын нам, засаг соёлын салбарыг хөгжүүлэх тал дээр ихээхэн хүчин чармайлт гаргаж, өөрчлөлт хийсэн ч хүссэн үр дүндээ хараахан хүрч амжаагүй байна. Олон нийтийн соёлын салбарын тухай ойлголт муу, бүрхэг байсаар байна. Вьетнамд соёлын бүтээгдэхүүний үйлдвэрлэл хангалттай хэмжээнд хүрч хөгжөөгүй, энэ чиглэлийн бизнес эрхлэгчдийн тоо нэмэгдсэн ч оролцоо нь ихэвчлэн жижиг хэвээр байна. Товчоор хэлбэл, Вьетнамын соёлын салбарын хөгжил энэ маягаар явбал дэлхийн хөгжингүй орнуудын хэмжээнд очиход тодорхой хугацаа шаардлагатай.

Зохиогчийн эрх зөрчих асуудал: Вьетнамын соёлын бүтээгдэхүүний зах зээлд тулгарч буй том саад бэрхшээл нь зохиогчийн эрхийн асуудал. Тухайлбал хэвлэл, гүйцэтгэл, дуу хөгжим, кино, цахим тоглоом, загвар, зураг төсөл зэрэг ихэнх үйл ажиллагаа нь бүх нутаг дэвсгэрийн хэмжээгээр бүрэн хяналтанд байж чадахгүй

10. Nguồn số liệu: Báo cáo tổng kết 15 năm thi hành Luật Báo chí của Bộ Thông tin và Truyền thông, (Мэдээлэл, харилцаа холбооны яамны Хэвлэл мэдээллийн тухай хуулийг хэрэгжүүлэхтүхай 15 жилийн ажлын нэгдсэн тайлан мэдээ).

11. Nguồn: Báo cáo của Đại truyền hình Việt Nam, Hà Nội – 2016, (Вьетнамын үндэсний телевизийн 2016 оны тайлан мэдээ).

байгаа ба зохиогчийн эрхийг зөрчиж байгаа нь соёлын салбарын хөгжилд саад учруулж, соёлын бүтээгдэхүүнийг түгээх, ашиг олох зэрэгт үйлдвэрлэгчдэд хүндрэл учруулсан хэвээр байна. Зохиогчийн эрхийг зөрчсөн ямар ч тохиолдолд цаг тухайд нь зохистой арга хэмжээ авч байгаа хэдий ч хангалтгүй байна. Ийм учраас соёлын салбарын тухай ойлголт, зохиогчийн эрхийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, ард иргэдэд эзэмшүүлэх талаарх сургалт сурталчилгаа, нэгдсэн аяныг ойрын үед явуулах нь чухал юм.

Удирдлагын тогтолцоо, хөрөнгө оруулалтын загвар төдийлэн үр дүнтэй биш: Соёлын салбарыг хөгжүүлэхэд хэрэгтэй санхүүгийн хөрөнгө оруулалт нь хөрөнгө оруулалт ба ашгийн нэмэгдэлээс бүрдэнэ. Вьетнамын соёлын салбар дахь хөрөнгө оруулалт хангалтгүй байгаа нь нэг талаас удирдлагын буруу тогтолцоотой холбоотой. Үүнээс гадна, хөрөнгө оруулалт нь голдуу улсын төсвөөс гардаг ба бизнесийн бүтэц, зарчимнь уян хатан бус хэвээр байгаа нь цаашид төрийн хараат байдал ноёрхсоор байхад хүргэж болзошгүй. Тиймээс соёлын салбарын хөрөнгө оруулалтын механизмыг шинэчилж, зах зээлийн эдийн засгийн хөрөнгө оруулалтын механизмыг бий болгох зайлшгүй шаардлагатай байна. Зөвхөн хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлээд зогсохгүй удирдлагын тогтолцоог сайжруулах, соёлын болон бусад салбарын харилцан уялдаа, оролцоог бий болгох асуудалд анхаарлаа хандуулах нь зүйтэй.

3. Дүгнэлт

Соёлын бодлого, соёлын салбарын хөгжлийн бодлогын шинэчлэл нь бусад салбар, түүний дотор эдийн засгийн хөгжлийн бодлоготой харьцуулахад тогтвортой явагдаж байна. Энэ нь соёлын үйл ажиллагаа, соёлын салбарын хөгжилд ихээхэн нөлөөтэй удирдлагын болон хууль, эрх зүйн нөхцлийг бий болгосонтой холбоотой юм. Вьетнамын соёлын салбарт харьяалагдах аж ахуйн нэгжүүд соёлын салбарыг хөгжүүлэх төрийн бодлогод суурилсан тогтолцоо руу шилжиж байна. Энэ нь эхлэлийн шатанд байгаа соёлын салбарын бүтээгдэхүүнийг өргөн, гүн тархах замаар нөхөн сэргээх, үндэсний соёлын үнэт зүйлсийг хөгжүүлэх шинэ уур амьсгалыг бий болгож байгаа өөрчлөлт юм. Вьетнамын соёлын салбарын хөгжил, боломж, бэрхшээлийн аль аль нь шинэ шатанд тулж ирээд байна. Олон улсын интеграци нь соёлын

сайн бүтээгдэхүүн, боломжийг түүнээс дутуугүй асар их дарамтын хамт авчирсан байна. Ийм нөхцөлд, соёлын салбарын хувь заяа ирээдүйд хэрхэх нь зарим талаар Вьетнамын Засгийн газрын бодлого зохицуулалтаар дамжин бодлого, шинэчлэлийн дараагийн алхамаас шууд хамаарна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Đinh Văn Bn, Vx Trn Thanh, Thể chế, cải cách thể chế và phbт triển – Ln luận và thực tiễn ở nước ngoài và Việt Nam, (Институцийн зохион байгуулалтын шинэчлэл ба хөгжил - Гадаадын орнуудын болон Вьетнамын онол, туршлага), NXB Thống Kk, 2002.
2. Ban chấp hành Trung ương, Ban Kinh tế, Phbт triển ngành công nghiệp văn hуа Việt Nam trong hội nhập quốc tế, (Олон улсын интеграцийн хүрээнд Вьетнамын соёлын салбарыг хөгжүүлэх нь), Ha Nội, 2015.
3. Bộ Văn hуа, Thể thao và Du lịch, Dự thảo “Chiến lược phbт triển cбc ngành công nghiệp văn hуа Việt Nam đến năm 2020, tầm nhмn đến năm 2030”, (Вьетнамын соёлын салбарыг 2020-2030 онд хөгжүүлэх стратеги), Ha Nội, 4/2016.
4. Bộ Văn hуа, Thể thao và Du lịch, Bбo cбo tổng kết Bộ Văn hуа, Thể thao và Du lịch năm 2015, (Соёл, спорт, аялал жуулчлалын яамны 2015 оны нэгдсэн тайлан мэдээ).
5. Chiến lược phbт triển văn hуа đến năm 2020, (Вьетнамын соёлын салбарыг 2020-2030 онд хөгжүүлэх стратеги), Ban hành kim theo Quyết định số 581/QĐ-TTg ngay 06 thбng 05 năm 2009 của Thủ tướng Chnh phủ Việt Nam.
6. Đảng Cộng sản Việt Nam, Văn kiện Hội nghị lần thứ năm Ban Chấp hành Trung ương khoa VIII, (ВКНамын Төв Хорооны VIII бүгд хурлын V хуралдааны тэмдэглэл), Nxb Chnh trị Quốc gia, Ha Nội, 1998.
7. Phạm Hồng Thбi (Chủ bикn), Sự phbт triển của công nghiệp văn hуа Nhật Bản và Han Quốc, (Япон, Өмнөд Солонгосын соёлын салбарын хөгжил), Nxb. Khoa học хг hội, Ha Nội – 2015.

8. Chủ Văn Thu, Chiến lược phát triển công nghiệp văn hóa của Trung Quốc, (Хятадын соёлын салбарын хөгжлийн бодлого), Tạp chí Nghiên cứu Trung Quốc, số 10 – 2015.
9. Đỗ Thanh Thủy, Đề phát triển các ngành công nghiệp văn hóa ở Việt Nam, (Вьетнамын соёлын салбарын хөгжилд), Tạp chí Văn hóa học số 6, 2014.
10. UNESCO, Các ngành công nghiệp văn hóa - Tầm nhìn của văn hóa trong tương lai, (Соёлын салбар-ирээдүйн соёлын төв), Website: <http://portal.unesco.org/culture/en/ev>.

Вьетнам хэлнээс орчуулсан:

ОУХХ-ийн Бүс нутаг, олон улсын байгууллагын салбарын ЭША,
доктор (Ph.D) Б.Цэнгэлхам